

САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан "Хөгжлийн бодлогын санхүүжилт-2" хөтөлбөрийн Санхүүжилтийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ

Зээлийн дугаар 4776-MN

Монгол Улс

болон

Олон улсын хөгжлийн ассоциаци

хоорондын

Санхүүжилтийн хэлэлцээр

(Хөгжлийн бодлогын санхүүжилт-2)

2010 оны 10-р сарын 26-ны өдөр

САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү Хэлэлцээрийг МОНГОЛ УЛС ("Хүлээн авагч") болон ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ ("Ассоциаци")-ийн хооронд Хөтөлбөр (энэхүү гэрээний Хавсралтад тодорхойлсон)-ийн хэрэгжилтийг хангахад зориулж санхүүжилт олгох зорилгоор 2010 оны 10 дугаар сарын 26-ны өдөр байгуулав. Ассоциаци нь (а) энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр Хуваарийн I дэх хэсэгт тодорхойлсон бөгөөд Хөтөлбөрийн хүрээнд Хүлээн Авагчийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүнчлэн (б) Хүлээн авагчийн зүгээс макро эдийн засгийн зохистой бодлого хэрэгжүүлж байгаа зэрэг нөхцөл байдлыг үндэс болгон энэхүү санхүүжилтийг олгохоор шийдвэрлэв. Иймд Хүлээн авагч болон Ассоциаци дараахь зүйлийг харилцан тохиролцов. Үүнд:

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ — ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ; НЭР ТОМЪЁО

Ерөнхий нөхцөл (энэхүү Хэлэлцээрийн Хавсралтад тодорхойлсноор) нь энэхүү Хэлэлцээрийн салшгүй хэсгийг бүрдүүлнэ.

Тухайн агуулгад өөрөөр заагаагүй тохиолдолд энэхүү Хэлэлцээрт том үсгээр тэмдэглэсэн нэр томъёо нь Ерөнхий нөхцөл эсвэл Хэлэлцээрийн Хавсралтанд тодорхойлсон утгыг илэрхийлнэ.

2 ДУГААР ЗҮЙЛ — САНХҮҮЖИЛТ

Ассоциаци нь энэхүү Хэлэлцээрт заасан буюу дурдсан нөхцөл, болзлын дагуу арван есөн сая долоон зуун мянган зээлжих тусгай эрх (ЗТЭ 19,700,000)-тэй тэнцэх хэмжээний зээл ("Зээл" буюу "Санхүүжилт")-ийг Хүлээн авагчид олгохыг зөвшөөрөв. Хүлээн авагч нь энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр Хуваарийн II хэсэгт заасны дагуу Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор санхүүжилтийн эх үүсвэрийг авч ашиглаж болно. Хүлээн авагч Санхүүжилтийн хөрөнгийн ашиглагдаагүй үлдэгдэлд Хөрөнгө нөөцлөн батагаажуулсны дээд хураамжийг нэг жилд нэг хувийн хагас (1%-ийн 1/2) —ын хэмжээгээр төлнө.

2.04. Зээлийн хөрөнгөөс зарцуулсан үлдэгдэлд Хүлээн авагчийн төлөх Үйлчилгээний Хураамж нь жилд 1 хувийн дөрөвний гурав (1%-ийн 3/4) байна.

2.05. Төлбөр хийгдэх өдрүүд нь жил бүрийн 4 дүгээр сарын 15 болон 10 дугаар сарын 15-ны өдөр байна.

2.06. Зээлийн үндсэн өрийн эргэн төлөлтийг энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар Хуваарьт заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу хийнэ.

2.07. Төлбөрийн валют нь АНУ-ын доллар байна.

3 ДУГААР ЗҮЙЛ — ХӨТӨЛБӨР

3.01 Хүлээн авагч нь Хөтөлбөрийн дагуу хүлээсэн үүрэг болон түүний хэрэгжилтийг мэдүүлж байна. Энэ үүднээс:

(а) Хүлээн авагч болон Ассоциаци нь, аль нэг талын гаргасан хүсэлтийн дагуу Хүлээн авагчийн макро эдийн засгийн бодлогын хүрээ болон Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр гаргасан ахиц дэвшлийн талаар тухай бүр санал солилцож байна;

(б) Ийнхүү санал солилцохоос өмнө, Хүлээн авагч нь Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр гаргасан ахиц дэвшлийн талаархи тайланг Ассоциацийн хүссэн хэлбэр, агуулгаар гаргаж, хянуулан санал дүгнэлт авна; мөн

(в) Энэхүү хэсгийн (а), (б) заалтаар хязгаарлагдахгүйгээр, Хүлээн авагч нь хөтөлбөрийн үндсэн зорилтыг ноцтойгоор өөрчилж болзошгүй нөхцөл байдал эсхүл Хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тэр дундаа энэхүү Хэлэлцээрийн 1 дүгээр Хуваарийн I Хэсэг-т заасан аливаа арга хэмжээний талаар Ассоциацид шуурхай мэдэгдэнэ.

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ — АССОЦИАЦААС АВАХ ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

4.01. Түдгэлзүүлэх нэмэлт нөхцөл гэж Хөтөлбөр эсвэл түүний дийлэнхи хэсгийг хэрэгжүүлэх боломжгүй болох нөхцөл байдал үүссэнийг хэлнэ.

4.02. Хурдавчлах нэмэлт нөхцөл гэж энэхүү Хэлэлцээрийн 4.01 Хэсэгт заасан нөхцөл байдал үүсч, энэ нь Хүлээн авагчид Ассоциациас мэдэгдэл өгснөөс хойш жар (60) хоног үргэлжилэхийг хэлнэ.

5 ДУГААР ЗҮЙЛ — ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ; ЦУЦЛАХ

5.01. Хүчин төгөлдөр болох нэмэлт нөхцөл гэж Ассоциаци нь Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Хүлээн авагчийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээг хангалттай гэж үзэж, мөн Хүлээн авагчийн макро эдийн засгийн бодлогын хүрээнд нийцэж байгааг хүлээн зөвшөөрсөн байхыг хэлнэ.

5.02. Хүчин төгөлдөр болох эцсийн хугацаа нь энэхүү Хэлэлцээрийг байгуулснаас хойш зуун хорь (120) дахь хоног байна.

6 ДУГААР ЗҮЙЛ — ТӨЛӨӨЛӨГЧ; ХАЯГ

6.01. Хүлээн авагчийг төлөөлөгч нь түүний Сангийн Сайд байна.

6.02. Хүлээн авагчийн хаяг:

Сангийн яам

Засгийн газрын 2-р байр

Нэгдсэн үндэстний гудамж 5/1

Улаанбаатар хот, 15160

Факс:

976-11-262272

6.03. АССОЦИАЦИ-ийн хаяг:

International Development Association

1818 H Street, N.W.

Washington, D.C. 20433

United States of America

Кабель холбоо: Телекс: Факс:

INDEVAS 248423(MCI) 1-202-477-6391

Washington, D.C.

Хэлэлцээрийг _____, _____-д дээр дурдсан өдөр байгуулав.

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ:

Эрх олгогдсон төлөөлөгч

ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИЙГ ТӨЛӨӨЛЖ:

1 ДҮГЭЭР ХУВААРЬ

Хөтөлбөрийн арга хэмжээ; Санхүүжилтийн хөрөнгийг ашиглах

Хэсэг I. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

Хөтөлбөрийн хүрээнд Хүлээн авагчаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь дараахь зүйлсийг багтаана. Үүнд:

Хүлээн авагч 2010 оны Төсвөө дараахь зорилгоор тодотгосон:

Улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг сайжруулах, ингэхдээ [] төгрөгийн дүн бүхий дараахь төслүүдийг оруулахгүй. Үүнд: (а) шаардлагатай техник, эдийн засгийн үндэслэл нь боловсрогдоогүй (техникийн зураг төсөл болон төсөвт өртгийн тооцоо) (б) үндэсний тэргүүлэх ач холбогдолтой төслийн шаардлагыг хангаагүй; мөн,

2010 оны тодотгосон төсөвт тусгах замаар дараа төлбөрт гэрээлэгч-санхүүжүүлэх төслүүдийн болзошгүй өр төлбөрийг тооцоолсон.

Хүлээн авагч: (i) их засварын зардлын шинэ хөрөнгө оруулалттай харьцах харьцааг 6.1% (2009 оны тодотгосон төсөвт)-ээс 6.5% (2010 оны төсөвт) хүртэл нэмэгдүүлж (ii) энэ зорилгоор 28.7 тэрбум төгрөгийг хуваарилснаар суурь дэд бүтцийн (Замын санг оролцуулаад) засвар арчлалтын түвшинг тэргүүлэх зэрэгт авч үзсэн.

Үндэсний Статистикийн хороо Монгол улсад нийгмийн халамжийн мөнгийг зорилтот бүлэгт чиглүүлэх албан ёсны механизм болгон Орлого орлуулан тооцох аргачлалыг баталсан.

НХХЯ ядуу, эмзэг бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн шинэ хөтөлбөрийн үзүүлэлтийг тодорхойлсон саналаа бэлтгэж Засгийн газарт батлуулахаар хүргүүлсэн.

Монголбанк гадны нэр хүндтэй аудиторын туслалцаатайгаар (i) сонгогдсон долоон банкны тусгайлсан үнэлгээг хийж дуусгасан, мөн (ii) сонгогдсон гурван банкны тусгайлсан үнэлгээг хийж эхэлсэн.

Монголбанк хамгийн эцсийн арга хэмжээ болох хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг хамгаалахад чиглэгдсэн зөв, зохистой хэлцэл бүхий банкуудыг дахин хөрөнгөжүүлэх нэг удаагийн хэрэгслийг багтаасан банкны бүтцийн өөрчлөлтийн стратегийг батлан УИХ-д өргөн барьсан.

Хүлээн авагч уул уурхайн кадастрийн процесс болон үйл ажиллагааны зохицуулалтыг боловсронгуй болгосон.

Хүлээн авагчийн ОУИТБС-ийн үндэсний хөтөлбөрийн нийцэлтийн үнэлгээ хийхэд шаардагдах баримт бичгийг Хүлээн авагч Олон улсын ОУИТБС-ийн Зөвлөлд хүргүүлсэн.

Хүлээн авагч уул уурхайн болон бусад төслүүдийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хайлт хийх боломж бүхий мэдээллийн баазыг онлайн байршуулсан.

Хэсэг II. Санхүүжилтийн хөрөнгийг ашиглах

А. Ерөнхий нөхцөл. Хүлээн авагч нь энэхүү хэсгийн заалт болон Ассоциациас Хүлээн авагчид мэдэгдсэн нэмэлт зааврын дагуу Санхүүжилтийн хөрөнгийг гарган авч болно.

В. Санхүүжилтийг хуваарилах. Санхүүжилтийн хөрөнгийг нэг удаагийн төлбөрөөр гаргана. Үүнтэй холбогдох санхүүжилтийн хуваарилалтыг доорх хүснэгтэд харуулав:

Хуваарилалт	Хуваарилсан санхүүжилтийн хэмжээ (ЗТЭ-ээр илэрхийлсэн)
Нэг удаагийн гаргалт	19,700,000
НИЙТ ДҮН	19,700,000

С. Хөрөнгө гаргах төлбөрийн нөхцөл.

АССОЦИАЦИ (а) Хүлээн авагчийн авч хэрэгжүүлсэн Хөтөлбөр болон (б) Хүлээн авагчийн макро эдийн засгийн бодлогыг зөв зохистой

хэмээн хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Нэг удаагийн төлбөрөөр хөрөнгө гаргах боломжгүй.

D. Санхүүжилтийн хөрөнгийг байршуулах. Ассоциаци өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд:

- 1. АССОЦИАЦИ нь Санхүүжилтийн данснаас гарган авсан бүх хөрөнгийг Хүлээн авагчийн нээсэн бөгөөд АССОЦИАЦИ-ийн шаардлагад нийцсэн тусгай дансанд байршуулна;
- 2. Дээрхи дансанд санхүүжилтийн хөрөнгийг байршуулснаар Хүлээн авагч нь төсвийн удирдлагын системд ижил дүнтэй хөрөнгийг АССОЦИАЦИ-ийн шаардлагад нийцсэн байдлаар өөрийн валютаар тусгах үүргийг хүлээнэ.

E. Хориглосон зардлууд. Хүлээн авагч нь Санхүүжилтийн хөрөнгийг хориглосон зардлыг санхүүжүүлэхэд ашиглахгүй байх үүргийг хүлээнэ. Санхүүжилтийн хөрөнгийг ямар нэг Хориглосон зардлын төлбөрт ашигласан болохыг АССОЦИАЦИ хэзээ нэгэн цагт олж тогтоовол Хүлээн авагч нь АССОЦИАЦИ-иас мэдэгдэл авсан даруйд тэрхүү төлбөрийн дүнтэй тэнцүү хэмжээний эх үүсвэрийг АССОЦИАЦИ-д нөхөж төлнө. Ийм хүсэлтээр АССОЦИАЦИ-ид нөхөн төлсөн дүнг цуцлана.

F. Хаалтын өдөр. Хаалтын өдөр нь 2011 оны 06 дугаар сарын 30-ны өдөр байна. 2 ДУГААР ХУВААРЬ

Эргэн төлөлтийн хуваарь

Төлбөр хийгдэх өдөр	Эргэн төлөх үндсэн зээлийн хэмжээ (хувиар илэрхийлсэн)*
4 дүгээр сарын 15 болон 10 дугаар сарын 15-ны өдөр бүр:	
2021оны 10 дугаар сарын 15-наас эхлэн 2030 оны 4 дүгээр сарын 15-ныг хүртэл(тус өдрийг оролцуулан)	1%
2031 оны 10 дугаар сарын 15-наас эхлэн 2050 оны 4 дүгээр сарын 15-ныг хүртэл (тус өдрийг оролцуулан)	2%

* Энэхүү хувь хэмжээ нь Ерөнхий нөхцлийн Хэсэг 3.03 (б) хэсэгт заасны дагуу АССОЦИАЦИ өөрөөр тогтоогоогүйгээс бусад тохиолдолд төлбөл зохих Зээлийн үндсэн төлбөрийн хувь хэмжээг илэрхийлнэ.

ХАВСРАЛТ

I Хэсэг. Нэр томьёо

"2010 оны төсвийн тодотгол" гэж [] өдөр төсвийн тодотгол хийх хуулийн дагуу тодотгол хийгдсэн 2010 оны Улсын төсвийг хэлнэ.

"Монголбанк" гэж 1996 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр батлагдсан Монгол Улсын Төв банкны тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан Хүлээн авагчийн төв банкийг хэлнэ.

"Засгийн Газар" гэж Хүлээн авагчийн Сайд нарын багыг хэлнэ.

"ОУИТБС-ийн хөтөлбөр" гэж хувийн компаниудын төлбөрийг нийтэд хэвлэх, газрын тос, хий, уул уурхайгаас Засгийн газарт орж буй орлогыг ил тод болгох замаар олборлох салбарт ил тод байдал, хариуцлагыг сайжруулан засаглалыг бэхжүүлэх зорилгоор Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлалыг хэрэгжүүлэхэд Засгийн газрын талаас оролцох төрийн захиргааны байгууллагуудын гүйцэтгэх чиг үүргийг батлах тухай 2007 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн Засгийн газрын тогтоолоор баталсан Хүлээн авагчийн хөтөлбөрийг хэлнэ.

"Хориглосон зардлууд" гэж:

(а) АССОЦИАЦИ эсвэл Банкнаас бусад олон улсын эсхүл үндэсний санхүүгийн аливаа байгууллага, агентлагаас санхүүжүүлсэн буюу санхүүжүүлэхээр зөвшөөрсөн эсвэл өөр зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд АССОЦИАЦИ эсвэл Банк санхүүжүүлсэн буюу санхүүжүүлэхээр тохирсон гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа, үйлчилгээний зардлууд;

(B) АССОЦИАЦИ-иас Хүлээн авагчид мэдэгдэн заасан Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргасан Статистикийн эмхэтгэлийн М цувралын 34-р дугаарын 3-д (1986 он)(SITC) хэвлэгдсэн Гадаад худалдааны жишиг ангиллын 3 дахь найруулга (SITC, REV.3)-д заасан дараахь бүлэг, дэд бүлэгт эсвэл SITC-ийн дараа дараачийн найруулгад орсон бүлэг, дэд бүлэгт багтах бараатай холбогдон гарах зардал:

Бүлэг	Дэд бүлэг	Тайлбар
112		Согтууруулах ундаа

121		Үйлдвэрийн бус аргаар боловсруулсан тамхи, тамхины хаягдал
122		Үйлдвэрийн аргаар боловсруулсан тамхи, (тамхины орлуулагч агуулсан эсвэл агуулаагүй)
525		Цацраг идэвхт, түүнтэй холбоотой материалууд
667		Зассан болон засаагүй сувд, үнэт болон хагас үнэт чулуу
718	718.7	Цөмийн реактор, түүнийг бүрдүүлэгч элементүүд; цөмийн реакторт зориулсан туяагаар шараагүй түлшний элементүүд (цэнэг),
728	728.43	Тамхи боловсруулах тоног төхөөрөмж
897	897.3	Алт, мөнгө, платинумын бүлгийн металаар хийсэн гоёл чимэглэл (бугуйн цаг ба түүний хайрцагаас бусад), алтан болон мөнгөний дарханы эдлэл (үүнд зассан үнэт чулуу багтана)
971		Мөнгөжөөгүй алт (алтны хүдэр, баяжмалаас бусад)

(C) цэргийн болон хагас цэргийн зориулалттай бараа эсвэл тансаг хэрэглээний барааны зардал;

(D) Хүлээн авагчийн хууль тогтоомжоор эсвэл түүний нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу үйлдвэрлэх, ашиглах буюу импортлохыг хориглосон хүрээлэн буй орчинд аюултай бараатай холбогдон гарах зардал;

(E) Нэгдсэн үндэстний байгууллагын Дүрмийн VII Бүлгийн дагуу НҮБ-ийн Аюулгүйн Зөвлөлөөс гаргасан шийдвэрээр хориглосон аливаа төлбөрт үндэслэсэн зардал;

(F) Хүлээн авагч эсвэл Санхүүжилтийн хөрөнгийн өөр хүлээн авагчийн төлөөлөгчид авилга, залилан, хуйвалдаан, айлган сүрдүүлэх үйл ажиллагаанд холбогдсон гэж АССОЦИАЦИ-иас үзсэн бөгөөд ийм үйлдэл гарахад (эсвэл өөр хүлээн авагч) АССОЦИАЦИ-ийн шаардлагад нийцэхүйц зохистой арга хэмжээг шуурхай аваагүйтэй холбогдон гарах зардал.

"Санхүүгийн жил" гэж тухайн календарийн жилийн 1 дүгээр сарын 1-нээс эхэлж 12 дугаар сарын 31-ны өдөр дуусгавар болох Хүлээн авагчийн санхүүгийн жилийг хэлнэ.

"2009 оны Төсвийн тодотгол" гэж 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдөр хийгдсэн тодотголыг тусгасан Хүлээн авагчийн 2009 оны санхүүгийн жилийн төсвийн хуваарилалт болон дансдыг баталгаажуулсан 2008 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуулийг хэлнэ.

"2010 оны санхүүгийн жилийн төсөв" гэж Хүлээн авагчийн 2010 оны санхүүгийн жилийн төсвийн хуваарилалт болон дансдыг баталгаажуулсан 2009 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуулийг хэлнэ.

"Ерөнхий нөхцөл" гэж 2005 оны 7-р сарын 1-нд батлагдсан "Олон улсын хөгжлийн Ассоциацийн зээл, буцалтгүй тусламж олгох ерөнхий нөхцөл" (2006 оны 10-р сарын 15-ны өдөр хүртэлх нэмэлт өөрчлөлтийн хамт)-ийг энэ Хавсралтын Хэсэг II-т заасан нэмэлт өөрчлөлтийн хамт хэлнэ.

"Олон улсын ОУИТБС-ийн зөвлөл" гэж Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын холбооны Дүрмийн 10 дугаар заалтын дагуу байгуулагдаж, Норвеги Улсын хуулийн үйл ажиллагаа явуулдаг Зөвлөлийг хэлнэ. "Уул уурхайн Кадастр" гэж Хүлээн авагчийн 2008 оны эрдэс баялгийн хуулийн 11 дүгээр зүйлийн дагуу байгуулагдсан, уул уурхайн лицензийн асуудал хариуцсан төрийн байгууллагыг хэлнэ.

"СЯ" гэж хүлээн авагчийн Сангийн яамыг хэлнэ.

"НХХЯ" гэж Хүлээн авагчийн Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамыг хэлнэ.

"Үндэсний Статистикийн Хороо" гэж Хүлээн авагчийн 1994 онд нэмэлт өөрчлөлт оруулсан Үндэсний Статистикийн тухай хуулийн дагуу байгуулагдсан Үндэсний статистикийн хороог хэлнэ.

"Улсын Их Хурал" гэж Хүлээн авагчийн Улсын Их Хуралыг хэлнэ.